



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.03.15

№

567

танай

-ны №

-т

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 12,830.0 мянган төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



002033459

НИЙСЛЭЛ ДЭХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/64/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Уваа Уул Аудит ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа Утас: 99108763 Цахим хаяг: uua.audit@gmail.com Аудитор: Ц.Саранцэцэг Утас: 93040983 Цахим: sarantsetsegts428@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТБОНӨХБАҮХАТХ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан авах тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03. 15 № 561
танай _____-ны № _____-т

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ-ЫН
ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр нь байгууллагын дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээтэй зөрсөн, төсөвт үйлдвэрийн газар хэдий ч орон нутгийн төсвөөс 100 хувийн санхүүжилт авдаг байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэж, төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлан гаргадаг байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан контрактын гэрээний шалгуур үзүүлэлтээр 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,663,367.56	110,948,717.64
35	БАРАА МАТЕРИАЛ	111,663,367.56	110,948,717.64
351	Түүхий эд материал	3,128,950.00	178,950.00
35110	Тусгай зориулалттай материал	2,981,950.00	31,950.00
35130	Эм боох материал	147,000.00	147,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	12,707,979.56	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	4,798,966.84
354	Хангамжийн материал	38,279,350.00	35,178,520.80
35410	Бичиг хэргийн материал	484,440.00	429,440.00
35420	Аж ахуйн материал	2,317,800.00	5,130,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,910,000.00	4,889,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	109,053.00
35470	Бусад хангамжийн материал	33,567,110.00	24,620,927.80
35600	Мал амьтад	57,547,088.00	70,792,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,593,964,837.46	1,418,333,758.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,593,964,837.46	1,418,333,758.26
392	Биет хөрөнгө	1,592,722,670.56	1,417,967,091.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	909,854,256.00	909,854,256.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,279,389.17)	(77,132,512.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	563,363,658.00	563,363,658.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(325,565,691.24)	(381,687,057.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	627,438,763.96	627,438,763.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(339,765,495.33)	(401,032,122.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,371,897.00	30,671,597.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,039,253.85)	(27,145,833.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	321,197,562.40	321,197,562.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(115,853,637.21)	(147,561,220.41)
393	Биет бус хөрөнгө	1,242,166.90	366,666.78
39301	Програм хангамж	1,020,000.00	1,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,020,000.00)	(1,020,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,955,000.00	4,955,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,712,833.10)	(4,588,333.22)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,705,628,205.02	1,529,282,475.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,705,628,205.02	1,529,282,475.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,705,628,205.02	1,529,282,475.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,705,628,205.02	1,529,282,475.90
51210	Өмнөх үеийн үр дүн	1,705,628,205.02	1,705,628,205.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(176,345,729.12)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,705,628,205.02	1,529,282,475.90

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	383,549,933.09	376,303,688.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,333,133.09	21,844,650.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,333,133.09	21,844,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,333,133.09	21,844,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,103,000.00	17,566,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,230,133.09	4,278,650.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,216,800.00	354,459,038.62
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,130,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,130,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	315,216,800.00	345,329,038.62
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,216,800.00	345,329,038.62
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	517,473,528.79	552,649,417.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,473,528.79	552,649,417.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,565,193.95	548,849,417.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,251,231.94	204,815,272.42
210101	Үндсэн цалин	102,061,969.94	113,216,852.75
210102	Нэмэгдэл	38,089,262.00	53,782,819.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,100,000.00	29,844,600.00
210104	Урамшуулал	-	7,971,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,510,204.68	26,211,819.57
210201	Тэтгэврийн даатгал	13,061,054.76	17,795,986.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,881,612.48	2,250,394.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,218,010.18	1,639,717.23
210204	Ажилгүйдлийн даатгал	304,502.30	426,429.10
210205	Эрүүл мэндийн даатгал	3,045,024.96	4,099,291.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,098,249.91	36,124,431.63
210301	Гэрэл, цахилгаан	4,563,049.91	3,021,231.63
210302	Түлш, халаалт	2,664,000.00	2,664,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	32,671,200.00	26,239,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,769,510.63	47,816,411.00
210401	Бичиг хэрэг	835,500.00	1,215,990.00
210402	Тээвэр, шатахуун	21,857,590.00	28,528,307.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,058,060.63	2,369,206.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	989,300.00	1,345,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,533,860.00	8,138,100.00
210408	Бараа материал акталсны зардал	5,495,200.00	6,219,808.00
2105	Нормативт зардал	2,112,400.00	2,220,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,392,400.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	720,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,314,899.00	2,386,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	969,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,314,899.00	1,416,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,400,068.00	26,870,277.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,500.00	7,252,784.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,460,000.00	5,717,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,800.00	254,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,456,000.00	1,499,500.00
210807	Газрын төлбөр	24,768.00	24,768.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	224,108,629.79	202,405,005.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,523,600.17	25,474,225.95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,585,029.62	176,930,779.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,908,334.84	3,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,505,500.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,005,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,402,834.84	3,300,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,402,834.84	3,296,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(133,923,595.70)	(176,345,729.12)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,839,551,800.72	1,839,551,800.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,839,551,800.72	1,839,551,800.72
Тайлант үеийн үр дүн	-	-	(133,923,595.70)	(133,923,595.70)
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,705,628,205.02	1,705,628,205.02
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,705,628,205.02	1,705,628,205.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,705,628,205.02	1,705,628,205.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(176,345,729.12)	(176,345,729.12)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,529,282,475.90	1,529,282,475.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	329,489,800.00	372,025,038.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,273,000.00	26,696,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,273,000.00	26,696,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,273,000.00	26,696,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,273,000.00	17,566,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	9,130,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	315,216,800.00	345,329,038.62
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	315,216,800.00	345,329,038.62
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,216,800.00	345,329,038.62
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	329,489,800.00	370,725,338.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,489,800.00	370,725,338.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,581,465.16	366,925,338.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,251,231.40	204,815,272.42
210101	Үндсэн цалин	102,061,969.40	113,216,852.75
210102	Нэмэгдэл	38,089,262.00	53,782,819.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,100,000.00	29,844,600.00
210104	Урамшуулал	00.00	7,971,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,510,205.22	26,211,819.57
210201	Тэтгэврийн даатгал	13,216,754.81	18,024,219.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,554,912.33	2,048,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	952,000.00	1,637,599.93
210204	Ажилгүйдлийн даатгал	552,513.42	408,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,234,024.66	4,093,799.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,098,249.91	36,124,431.63
210301	Гэрэл, цахилгаан	4,563,049.91	3,021,231.63
210302	Түлш, халаалт	2,664,000.00	2,664,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00
210304	Байрны түрээс	32,671,200.00	26,239,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,938,910.63	41,460,156.00
210401	Бичиг хэрэг	783,500.00	1,160,990.00
210402	Тээвэр, шатахуун	24,807,590.00	28,637,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,058,060.63	2,369,206.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,320,000.00	1,310,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,969,760.00	7,982,600.00
2105	Нормативт зардал	2,220,000.00	2,220,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	3,693,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	1,694,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,998,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,444,068.00	19,745,993.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,500.00	128,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,460,000.00	5,717,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,800.00	254,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,499,500.00
210807	Газрын төлбөр	24,768.00	24,768.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,118,800.00	32,654,666.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,118,800.00	32,654,666.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,908,334.84	3,800,000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	21,505,500.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,005,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,402,834.84	3,300,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,402,834.84	3,296,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,299,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,299,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,299,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,299,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,299,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	(1,299,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	359,861,400.00	359,599,038.62	262,361.38	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359,861,400.00	359,599,038.62	262,361.38	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,361,400.00	359,099,038.62	262,361.38	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,820,600.00	204,815,272.42	5,327.58	100.0
210101	Үндсэн цалин	122,234,200.00	113,216,852.75	9,017,347.25	92.6
210102	Нэмэгдэл	58,386,400.00	53,782,819.67	4,603,580.33	92.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,200,000.00	29,844,600.00	(5,644,600.00)	123.3
210104	Урамшуулал	-	7,971,000.00	(7,971,000.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,352,600.00	26,211,819.57	140,780.43	99.5
210201	Тэтгэврийн даатгал	18,159,600.00	18,024,219.65	135,380.35	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,048,700.00	2,048,200.00	500.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,638,600.00	1,637,599.93	1,000.07	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	409,300.00	408,000.00	1,300.00	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	4,096,400.00	4,093,799.99	2,600.01	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,038,100.00	35,038,099.63	0.37	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,934,900.00	1,934,899.63	0.37	100.0
210302	Түлш, халаалт	2,664,000.00	2,664,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	26,239,200.00	26,239,200.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	41,462,000.00	41,460,156.00	1,844.00	100.0
210401	Бичиг хэрэг	500,000.00	1,160,990.00	(660,990.00)	232.2
210402	Тээвэр, шатахуун	28,880,000.00	28,637,360.00	242,640.00	99.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,292,000.00	2,369,206.00	(77,206.00)	103.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,320,000.00	1,310,000.00	10,000.00	99.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,470,000.00	7,982,600.00	487,400.00	94.2
2105	Нормативт зардал	2,220,000.00	2,220,000.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720,000.00	720,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,992,700.00	7,300.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	2,994,000.00	6,000.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,998,700.00	1,300.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,848,100.00	19,745,993.00	102,107.00	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,000.00	128,500.00	1,500.00	98.8

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	5,717,600.00	5,717,425.00	175.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	295,500.00	254,800.00	40,700.00	86.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	125,000.00	121,000.00	4,000.00	96.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,499,500.00	500.00	100.0
210807	Газрын төлбөр	80,000.00	24,768.00	55,232.00	31.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,620,000.00	24,614,998.00	5,002.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,620,000.00	24,614,998.00	5,002.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	359,861,400.00	359,599,038.62	262,361.38	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	345,591,400.00	342,033,038.62	3,558,361.38	99.0
132001	Орон нутгийн төсвөөс	345,591,400.00	342,033,038.62	3,558,361.38	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,270,000.00	17,566,000.00	(3,296,000.00)	123.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,270,000.00	17,566,000.00	(3,296,000.00)	123.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,126,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,126,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		9,126,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,086,332.00
210301	Гэрэл, цахилгаан		1,086,332.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		8,039,668.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,039,668.00
213	Урсгал шилжүүлэг		4,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		4,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		9,130,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		9,130,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах”-д оршино гэж тодорхойлсон байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах;
- Австри улсын шинэ технологийг нэвтрүүлэх, дээрх технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр өөрийн фермийн үнээний сүүний гарцын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулах,
- Өвөл, хаврын улиралд ч шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломжийг бүрдүүлж, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дэвшилтэт технологийг малчдад нэвтрүүлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар статустай, Өмчийн 100.0 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” 213 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол “Журам батлах тухай” төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам;
- Засгийн газрын 2023 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 279 дүгээр тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг, аймгийн төвийн хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний

хэрэгцээнд зориулан бэлтгэх;

Нийслэлийн засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний газраас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулж 11 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй биологийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, дуусаагүй үйлдвэрлэл дансны бүртгэлийг тусгаагүй байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь санхүүгийн тайлангаа төсөвт байгууллагын хэрэглэдэг Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн асcolous программаар бэлтгэж байгаа нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дуусаагүй үйлдвэрлэл, өртөг тооцоолох боломжгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176,345.7 мянган төгрөг буюу 3.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	111,663.4	110,948.7	(714.6)
Үндсэн хөрөнгө	1,593,964.8	1,418,333.8	(175,631.1)
Нийт хөрөнгө	1,705,628.2	1,529,282.5	(176,345.7)
Засгийн газрын хувь оролцоо	1,705,628.2	1,529,282.5	(176,345.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,705,628.2	1,529,282.5	(176,345.7)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь бараа материал, үнсэн хөрөнгийн данс байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 110,948.7 мянган төгрөг болж 714.6 мянган төгрөгөөр буурсан нь 99,347.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 31,115.4 мянган төгрөгийн хангамжийн материал, 94,436.9 мянган төгрөгийн мал амьтад, 69,686.2 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүний дансанд шилжүүлэн авч, 295,301.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,418,333.8 мянган төгрөг болж 175,631.1 мянган төгрөгөөр буурсан нь урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,299.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 176,930.8 мянган төгрөгийн тайлант хугацааны элэгдлийн зардал гарснаас шалтгаалжээ.

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,529,282.5 мянган төгрөг болж, 176,345.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дарга үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ Нийслэлийн Засаг даргатай контрактын гэрээ байгуулаагүй, зорилтот түвшний төлөвлөгөө батлуулаагүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 345,591.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14,270.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 345,591.4 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны орлогоос 17,566.0 мянган төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 359,599.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,296.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	Код	Нэр				
1	70805	Хөдөө аж ахуй газар тариалан бодлого	359,861.4	359,599.0	262.4	99.9
	12	Төсөвт байгууллагын өөрийн орлого	14,270.0	17,566.0	(3,296.0)	123.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	345,091.4	341,533.0	3,558.4	98.9
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	500.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 9,130.0 төгрөгийн орлого бүрдүүлж байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,086.3 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 8,039.7 мянган төгрөгийг зарцуулж, 4.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, үнийн судалгаа хийж байх, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг аудиторов туслах Сампилмаа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ 2023 оны санхүүгийн тайлангаа Уваа уул Аудит ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 517,473.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,762.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь тайлант онд нийт 455,252.9 мянган төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн хөрөнгөөр 6,175.0 мянган төгрөгөөр 3.5 тн улаан буудайн үр тариа; 6,655.0 мянган төгрөгөөр 5.5 тн овъёосны үр худалдан авахдаа стратегийн хүнс импортлох тусгай зөвшөөрөлгүй, импортоор оруулж ирсэн шинжилгээний бичиггүй 2 аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.3."Захиалагч энэ хуульд заасан цахим системд бүртгэлтэй аж ахуй эрхлэгчдэд үнийн санал дуудах урилга хүргүүлнэ" гэсэн заалтыг хангаагүй

Шийдвэрлэсэн нь: стратегийн хүнс импортлох тусгай зөвшөөрөлтэй, импортоор оруулж ирсэн шинжилгээний бичигтэй аж ахуй нэгжээс худалдан авалт хийж байх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 46,843.4 мянган төгрөгийн 13 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 34,013.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 12,829.9 мянган төгрөгийн 3 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,533.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелэсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,533.0	2	5,533.0	-	-	100
Нийт дүн	2	5,533.0	2	5,533.0	-	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хөрөнгийн ашиглалт болон байрны түрээстэй холбоотой зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1:Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 67 нэр төрлийн 56,649.2 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай тогтоолын 7.1 “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж зөвшөөрөл авах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-2:Байгууллагын үндсэн үйл ажиллагаа явагдаж буй газарт конторын барилга байгууламж байхад Соёлын төв өргөөний байрыг түрээсэлж дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн 3 ажилтан түрээсийн төлбөрт 26,239.2 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:Хэрэгцээ шаардлагагүй, үргүй зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.	1	-					1	-				
2	байр түрээсэлж түрээсийн төлбөр төлсөн.	1	26,239.2					1	26,239.2				
	Дүн	2	26,239.2					2	26,239.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Ажлын хэсэг байгуулаагүй, 3 доошгүй хуулийн этгээдэд үнийн санал явуулж санал аваагүй, стратегийн хүнс импортлох тусгай зөвшөөрөлгүй, импортоор оруулж ирсэн шинжилгээний бичиггүй байхад 3.5 тн үр тариа, 5.5 тн овъёосны үр худалдан авсан	1.00	12,830.00			1.00	12,830.00		
	Дүн	1.00	12,830.00	-	-	1.00	12,830.00		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН

АУДИТОР



Ч. МӨНХТУЯА

Б.БУЯНДЭЛГЭР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 195/20180579

Улаанбаатар хот

ИТАС-2024/64/НА-СТА-ОНА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 6,175,000.00 (зургаан сая нэг зуун далан таван мянга) төгрөгөөр 3.5 тн улаан буудайн үр тариа; 6,655,000.00 (зургаан сая зургаан зуун тавин таван мянга) төгрөгөөр 5.5 тн овьёосны үр худалдан авахдаа стратегийн хүнс импортлох тусгай зөвшөөрөлгүй, импортоор оруулж ирсэн шинжилгээний бичиггүй 2 аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 "Захиалагч энэ хуульд заасан цахим системд бүртгэлтэй аж ахуй эрхлэгчдэд үнийн санал дуудах урилга хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1. "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Стратегийн хүнс импортлох тусгай зөвшөөрөлгүй, импортоор оруулж ирсэн шинжилгээний бичиггүй аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дарга Н.Ууганбаяр, нягтлан бодогч Ц.Мөнхдөл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.МӨНХТУЯА

Х.ТҮВШИНБАЯР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042824